



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2020 оны 09 сарын 18 өдөр

Дугаар A/139

Ховд

**Дотоод аудитын баг байгуулах тухай**

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 265 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааг сайжруулах, төрийн албан хаагчдын чадавхийг дээшлүүлэх, төрийн үйлчилгээг олон улсын жишигт нийцсэн ил тод, нээлттэй, хүнд суртал чирэгдэлгүй иргэдэд шуурхай хүргэх зорилгоор “Чанарын удирдлагын тогтолцоо” MNS ISO 9001:2016, “Байгаль орчны менежментийн тогтолцоо” MNS ISO 14001:2016 стандартуудын шаардлагыг нэвтрүүлсэнтэй холбогдуулан үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх, үл нийцлүүдийг тодорхойлох, үр дүнг тайлагнах чиг үүрэг бүхий “Дотоод аудитын баг”-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Аудитын багийн ахлагч: Х.Баасанхүү - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Гишүүд: Г.Жавзанхорлоо - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

Б.Цагаанцэцэг - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

2. Байгууллагын дотоод аудитын үйл ажиллагааг журам, стандартын дагуу шуурхай зохион байгуулж, хэрэгжилтийн явц, үр дүнг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргад тайлагнаж ажиллахыг “Дотоод аудитын баг”-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД